

БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Х.НЯМБААТАР

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.3-д “Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэнэ.” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан Өмгөөллийн тухай хуулиар иргэдийн хууль зүйн туслалцаа авах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах, өмгөөлөгч, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоож, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан.

Түүнчлэн хамт батлагдсан Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, Монголын Хуульчдын холбоо болон Өмгөөлөгчдийн Холбооны үйл ажиллагааг уялдуулах, чиг үүргийг оновчтой хуваарилах, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулахаар тусгагдсан болно.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт буюу Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах

болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж заасан.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Прокурорын тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Өмгөөллийн тухай хуульд тус тус зааснаар прокурорын ёс зүйн асуудлыг Прокурорын ёс зүйн зөвлөл болон шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудлыг Шүүхийн ёс зүйн хороо, өмгөөлөгчийн ёс зүйн асуудлыг Мэргэжлийн хариуцлагын хороо хянан шийдвэрлэхээр байна. Ингэснээр хуульчийн нэгдсэн хариуцлагын тогтолцоотой байх, түүнийг хэрэгжүүлэх асуудал нь эрх зүйн болон практик үндэслэлгүй болсон.

Түүнчлэн хуульд заасан “хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа”-ны нэр томъёоны талаарх зохицуулалтыг практик шаардлагыг үндэслэн оновчтой хувилбараар, харьцангуй өргөн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тусгах, мөн хуульчийн шалгалтад ороход мэргэжлийн дадлага хийсэнд тооцох зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэн боловсронгуй болгож, эрх зүйч мэргэжлээр төгссөн хүнийг хуульчаар ажиллах боломжийг нэмэгдүүлж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хангах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Хуульчийн шалгалтад хамрагдах этгээдийн хүрээг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан /Тухайлбал, Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нотариатын үйл ажиллагаа эрхлэх иргэн хуульч байх шаардлага шинээр тавигдсан зэрэг/ хуульчийн шалгалт, сургалтын чанарыг сайжруулах, боловсронгуй болгох, хуульч мэргэжлээр ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж, шалгалт нь сорил, бодлогын шалгалтаас гадна хуульчаар ажиллах итгэл үнэмшил, хандлага, мэргэжлийн ур чадварыг тодорхойлоход чиглэгдсэн байх нь зүйтэй байна.

Хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагаас хуульчийн сургалтыг зохион байгуулахдаа Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатын танхим, Шүүх, Прокурорын сургалт судалгааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах боломжийг бүрдүүлж, хуульчийн үргэлжилсэн сургалтын чанарыг сайжруулах, иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах үйл ажиллагаанд хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Монгол Улсад хууль зүйн үйлчилгээний чанарыг сайжруулах, хуульч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох нь дээд боловсролын сургалтын байгууллагаас эхлэх тул хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл сургалтын хөтөлбөрт хувийн эрх зүйн чиглэлийн сургалтыг тодорхой хувь, хэмжээнд заавал судлах зохицуулалтыг бий болгох замаар эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх шаардлагатай.

Түүнчлэн хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдал, бүтэц, зохион байгуулалтыг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд оновчтой, үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлсэн хувилбараар шинэчлэн тусгах шаардлага бий болоод байна.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр тус хуулийн холбогдох зохицуулалт нь зорилгодоо хүрээгүй

болон зорилгодоо хүрэхийн тулд хуулийн зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна гэж дүгнэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төслийн зорилтыг хуульчийн мэргэжлийн шалгалт, хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, хуульчид тавигдах шаардлага, хуульчийн нийтлэг эрх, үүргийг тодорхойлох, хуульч бэлтгэх сургалтын магадлан итгэмжлэл, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгана.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим зэргийг тусгана.

Хоёрдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шалгалт, түүнийг зохион байгуулах, хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох ажил, хуульчийн шалгалтад орох тухай өргөдөл гаргах зэрэг хуульчийн шалгалттай холбогдсон харилцааг тусгана. Энэхүү бүлгийн зохицуулалтыг боловсруулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн ерөнхий зарчмыг хэвээр хадгалах боловч шалгалтад орох өргөдөл гаргах журам, мэргэжлийн дадлагад тооцох ажил, албан тушаал зэргийн талаарх зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, эрх зүйч мэргэжилтэй этгээдийг хуульчаар ажиллах боломжийг харьцангуй өргөжүүлсэн хүрээнд, шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулахаар тусгана.

Гуравдугаар бүлэгт хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүнийг олгох журам, хуульчийн зөвшөөрөл олгох ажиллагааг түдгэлзүүлэх, хуульчийн зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэл, хуульчийн зөвшөөрлийг хүчингүй болгох, дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулна. Мөн хуульчдын бүртгэл, гадаад улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан иргэн Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт хуульчийн сургалт, түүний төрөл болон Хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага нь бусад эрх бүхий холбоо, танхим, судалгааны хүрээлэн, сургалтын байгууллагатай хамтран сургалтыг зохион байгуулах, хуульчийн багц цаг хангахтай холбоотой харилцааг тусгана.

Тавдугаар бүлэгт “хуульч” нэрийг хэрэглэх, хуульчийн нийтлэг эрх, үүрэг, түүнд хориглох зүйл, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нууц болон ёс зүйн дүрмийн талаарх зохицуулалтыг тусгана.

Зургадугаар бүлэгт хуульч бэлтгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага болон сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхтэй холбоотой харилцааг тусгана.

Долдугаар бүлэгт Хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллага, түүний бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгон тусгана.

Мөн тус бүлэгт хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагаас хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцах, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хууль бусаар оролцох, бие даасан байдалд нь нөлөөлөхийг хориглох зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар дараах үр дагавар гарна гэж үзэж байна:

Эрх зүйч мэргэжлээр төгссөн хүнд хуульчийн мэргэжлийн үйл ажиллах эрхлэх боломж, хүрээ нэмэгдэж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэний ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрх хангагдаж, нөгөө талаас иргэдэд үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, хүртээмж нэмэгдэнэ.

Хуульчийн шалгалт, үргэлжилсэн сургалтыг Хуульчдын холбоо, Нотариатын танхим, Өмгөөлөгчдийн холбоо, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Прокурорын сургалт, судалгааны төв зэрэг байгууллага хамтран зохион байгуулснаар сургалтын чанар сайжирч, хуульчдын хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэглэх нөхцөл бүрдэнэ.

Хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, хуульч бэлтгэх үйл ажиллагаа, эрх зүйч мэргэжил олгох дээд боловсролын сургалтын чанар сайжирна.

Түүнчлэн хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдал, бүтэц, зохион байгуулалт боловсронгуй болж, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд оновчтой, үр дүнтэй ажиллах боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслийг тус тус боловсруулна.